



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

**Ардчилсан намын даргаар бүртгүүлэх
хүсэлтийг хэлэлцэхээс татгалзах тухай**

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, Г.Банзрагч, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Г.Цагаанцоож, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардчилсан намын даргаар М.Тулгатыг, О.Цогтгэрэлийг бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнээс С.Эрдэнийг хасалт хийлгүүлэх тухай хүсэлтүүдийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Ч.Өнөрбаяр гэсэн гарын үсэгтэй, 2021.04.29-ний өдрийн 116 дугаартай албан бичигт "...Намын даргаар бүртгүүлэх хүсэлт гаргасан болохоос дотоод асуудлаа шийдвэрлүүлэх хүсэлт гаргаагүй, дотоод асуудлаа шийдвэрлэж, намын даргаа сонгосон тул бүртгэх боломжтой, намын даргаар С.Эрдэнийг бүртгэсэн Улсын дээд шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн тогтоол хүчинтэй байгаа, Ардчилсан намын дарга С.Эрдэнэ нь шинээр сонгогдсон, намын дарга эрх, үүргээ шилжүүлэн авах хүртэл бүрэн эрхтэй байхыг тогтоосон, ...намыг төлөөлөх эрхгүй этгээдийн хүсэлтээр, хүчингүй тамга ашиглан гаргасан хүсэлтийг шүүх хэлэлцэх учиргүй байсан, ...намын дотоод маргаан байхгүй" гээд нийт 19 хавтас, 2555 хуудас баримт хавсаргажээ.

Ардчилсан намын хэрэг эрхлэх газрын дарга Д.Бадарсан гэсэн гарын үсэгтэй, 2021.05.11-ний өдрийн 2/158 дугаартай албан бичигт "...2020.07.24-ний өдрийн Үндэсний бодлогын хорооны тогтоолоор С.Эрдэнийг намын даргаас огцруулсан, Улсын дээд шүүхийн Улс төрийн намын цахим бүртгэлийн сан дахь С.Эрдэнийн мэдээллийг хасч, тус цахим бүртгэлийн санд намын даргаар Ц.Тувааныг бүртгэсэн, ...2021.04.03-ны өдрийн ээлжит бус Их хурлаар О.Цогтгэрэлийг намын даргаар баталсан тул намын даргаар бүртгүүлэхээр хүсэлт гаргасан боловч Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж хангахаас татгалзсан. Иймээс 8082001002 улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулж, С.Эрдэнийг тухайн гэрчилгээнээс хасалт хийлгүүлэх" гээд нийт 8 хуудас баримт ирүүлсэн байна.

Ардчилсан намын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Бадарсан гэсэн гарын үсэгтэй, 2021.05.12-ны өдрийн 2/160 дугаартай албан бичигт “...Иргэн С.Эрдэнэ нь Ардчилсан намыг төлөөлөх, Үндэсний бодлогын хорооны хурал зарлах эрхгүй этгээд бөгөөд түүний дүрмийн бусаар зохион байгуулсан цахим хурал, цахим сонгуулийг хүчингүй болгосон, ...Дотоод сонгуулийн хорооны бүрэн эрх нь маргаангүй, өөрчлөлт ороогүй, шийдвэрүүд нь хүчинтэй, М.Тулгатыг бүртгүүлэх хүсэлтэд холбогдох шийдвэрт дарагдсан тамга хүчингүй байна” гээд нийт 48 хавтас, 13607 хуудас баримт ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭХ нь:

Ардчилсан намын даргаар М.Тулгатыг болон О.Цогтгэрэлийг бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнээс С.Эрдэнийг хасах тухай хүсэлтийг нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхээс татгалзах хууль зүйн үндэслэлтэй байна.

Учир нь хүсэлтэд дурдсан Ардчилсан намын даргаар М.Тулгатыг 2021.04.07-ны өдрийн цахим хурлаар ёсчлон баталсан, О.Цогтгэрэлийг 2021.04.03-ны өдрийн хурлаар сонгож баталсан гэх үйл баримтуудад Улсын дээд шүүх 2021.04.27-ны өдрийн 12 дугаар тогтоолоороо дүгнэлт өгсөн, энэхүү нөхцөл байдал өөрчлөгдөөгүй байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт “үүсгэн байгуулах баримт бичиг нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана” гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “өргөдөл гаргагч нь энэ хуулийн 18.1.1, 18.1.2-т заасан улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан зөрчлийг арилгасны дараа улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргаж болно” гэж заасан.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021.04.27-ны өдрийн 12 дугаартай тогтоолын 10 дугаар талд “...намын даргын сонгуулийг зохион байгуулсан Сонгуулийн байгууллагын шийдвэрүүд хоорондоо зөрчилтэй, Үндэсний бодлогын хороо хоёр өөр бүрэлдэхүүнээр тус тусдаа асуудлыг шийдвэрлэсэн нь Намын үндсэн дүрэмд нийцэхгүй” гэж дүгнэж, Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-д заасныг үндэслэн М.Тулгат, О.Цогтгэрэл нарыг бүртгэхээс татгалзжээ.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “...хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг биелүүлэх үүрэгтэй” гэж заасан, энэ тохиолдолд Ардчилсан нам нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 12 дугаар тогтоолын заалтыг биелүүлээгүй, зөрчилтэй баримтыг дахин ирүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дэх мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд баримт бичгийн эх хувь болон өмнө нь орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг хэвээр хадгална” гэж зааснаар бүртгэлийн байгууллага нь Улс төрийн намын бүртгэлд өөрчлөлт оруулахдаа өмнөх мэдээллийг өөрчлөхгүй, нөгөө талаар улсын бүртгэлийн гэрчилгээнээс С.Эрдэнийг 2017 онд намын даргаар бүртгэснийг хасуулах тухай хүсэлт нь Ардчилсан намын даргын бүртгэлтэй холбоотой, “...О.Цогтгэрэлийг намын даргаар бүртгүүлэх хүсэлт гаргасан боловч нийт шүүгчийн

хуралдаанаас татгалзсан” гэснээр өмнөх хүсэлттэй агуулга адил байгаа болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Иймээс нөхцөл байдал өөрчлөгдөөгүй, зөрчил арилаагүй байхад урьд шийдвэрлэсэн асуудлаар дахин шүүхэд хандсан байх тул хүсэлтүүдийг хэлэлцэх боломжгүй гэж нийт шүүгчийн хуралдаанаас шийдвэрлэлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Ардчилсан намын даргаар М.Тулгатыг, О.Цогтгэрэлийг тус тус бүртгүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээнээс С.Эрдэнийг хасуулах тухай хүсэлтийг нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэхээс татгалзсугай.

2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид 2021.04.29-ний өдөр төлсөн 150,000 төгрөг, 2021.05.12-ны өдөр төлсөн 300,000 төгрөгийг тус тус улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ